

ҮГИЙН ТАЯГИЙГ ТУЛСАН “ҮНЭН” СОНИНЫ ИХ ХИЧЭЭНГҮЙ

Л.Норовсүрэн*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн профессор

Түлхүүр үг: Их хичээнгүй, үгийн таяг, өнгө зүс, дүр төрх, найруулал, толь бичиг.

Монголын сэтгүүл зүйн 100 шахам жилийн түүхийг тэнд ажиллагч сэтгүүлчдийн ур чадварын урт сунгаа гэж бодвол үе үеийн авьяаслаг сэтгүүлчдийн бүтээлийг тэр сунгаанд шандас сорьсон аргамаг хүлгүүд гэлтэй. Тийм аргамаг хүлэг олныг тодруулсан уран бүтээлчийн нэг бол Монголын сэтгүүлчдийн дунд үеийн нэрт төлөөлөгч, ахмад сэтгүүлч, толь зүйч Ичинноровын Дамбажав билээ.

И.Дамбажав МУИС-ийг монгол хэл, уран зохиолын багш, ЗХУ-ын Коммунист намын дээд сургуулийг сэтгүүлч мэргэжлээр төгсгөөд соёл, боловсролын салбарт 60 жил хүчин зүтгэж яваа нэгэн. Түүний дотор “Үнэн” сонинд 30 жил тасралтгүй ажилласныхаа ихэнх хугацаанд “сонины гал тогоо” гэж нэрлэгддэг утга зохиолын нарийн бичгийн даргын албыг хашжээ.

Монгол хэлний багш, сэтгүүл зүй судлаач эрдэмтэд өнөөгийн сонин сэтгүүлийн хэл найруулга дордож, сэтгүүлч-

дийн үгсийн сан хомсдож байгаа тухай байнга ярьж, ийм байдлаас гарах арга замыг эрж хайцгаах болсон. Тэд аливаа буруу үг, найруулгын тухай ярих бүрдээ “Та нар дал, наяд оны “Үнэн” сониныг хар!” гэцгээдэг. Тэр үеийн “Үнэн” сонин үнэхээр зөв бичих, зөв найруулахын загвар болж чаддаг байснаас тийнхүү жишээлдэг болсон хэрэг.

Үг хэл, утга агуулга аль ч талаараа монголын тогтмол хэвлэлүүдийн сүр сүлд нь болж байсан тэрхүү “Үнэн” сонины утгын таягийг баригч — Их Хичээнгүй нь И.Дамбажав байсан юм. Тэрбээр сонин сэтгүүлийн хамгийн хүнд хэцүү, нарийн чимхлүүр ажилд цаг завгүй зүтгэхийн зэрэгцээ уран бүтээл, эрдэм судлалын ажлаа орхиогүй аж. Өнгөрсөн хугацаанд “Эхлэн бичигчдэд тусламж” (1980), Сонины өнгө зүс, дүр төрх” (1984), “Сонины онцлог үг хэллэг” (1986), “Сонин гаргах урлаг” (1988), “Сонин хэвлэлийн нэр томъёоны товч тайлбар толь” (1987) зэрэг сурах бичиг, гарын авлага зохиож хэвлүүлсэн нь нэгэн үеийн оюутан, залуу сэтгүүлч, эхлэн бичигчдийн ширээний ном болж байв. Тэдгээрийн дотроос “Сонин гаргах

урлаг” хэмээх 16 хэвлэлийн хуудас бүтээл нь манайд урьд өмнө нь гарч байгаагүй, хойшид ч гаргахад бэрх нүсэр ажил юм. Учир нь өнгөрсөн зууны ерээд оныг хүртэл хэвлэлийн салбарын үндсэн арга болж байсан өндөр хэвлэлийн технологид тулгуурлан сонин сэтгүүлийн дугаарыг бэлтгэх, нүүр буланг чимэглэх, материалын тооцоо хийх, үсэг материалыг сонгох, шугам, хээ ашиглах зэрэг дизайны бүхий л арга хэлбэрийг тэр номонд нарийн зааж өгсөн юм. Энэ бол хэвлэлийн үйлдвэрийн техникийн дэвшил, үсэг материалын сан хөмрөгийг нэвтэрхий мэддэг хүний хийх ажил мөн. Уг ном өнөөдөр нэн ховор эрдэнийн нэг болжээ.

И.Дамбажав манай хэд хэдэн үеийн сэтгүүлчдийг сургаж хүмүүжүүлсэн багш хүн юм. Далаад онд Намын дээд сургуульд, наяд онд Марксизм-ленинизмийн их сургууль, Монгол Улсын Их Сургуульд хичээл зааж, “Эхлэн бичигчдэд тусламж” номоороо сонин сэтгүүлд юм бичих хорхойтой олон арван залуусын замыг зааж өгсөн билээ. Наяад оны идэвхтэн бичигчид уг номыг дэлгэж тавьчихаад “Өгүүлэл, найрууллыг ингэж бич гэсэн байна” хэмээн суухтай олон удаа таарч билээ. 1987 онд хэвлүүлсэн “Сонины онцлог үг, хэллэг” гэдэг товхимол нь манай хэвлэл, олон нийтийн мэдээллийн салбарт өргөн хэрэглэгдэг нэр томъёог тайлбарлах анхны оролдлого болсон юм. Тэр товхимол тухайн үедээ хэвлэл мэдээллийн ажилтан, оюутан, сэтгүүлчдийн мэргэжлийн мэдлэгт томоохон хувь нэмэр болсон бөгөөд өнөөдрийг хүртэл тийм лавлах гараагүй л байна.

Уг товхимол хэвлэлийн үйлдвэрийн зарим тоног төхөөрөмж, хэмжүүрийн нэгж, ном хэвлэлийн ажил, бүтээлтэй холбоотой нэр томъёо, сэтгүүл зүйн онцлог үг хэллэгийг багтаан оруулсан нь өнөөдөр ч эрэлт хэрэгцээтэй хэвээр байгаа юм. Жишээ нь “Авторский лист” (Зохиогчийн хуудас) гэдэг үгийг бид хэлж заншсан боловч хэвлэлийн хэмжүүрийн системээр хэдий хэмжээний ойлголт болохыг олон хүн мэддэггүй. Тэгвэл “Хэвлэхээр өрсөн зохиол бүтээлийн багтаамжийн хэмжүүрийн нэгж, хэвлэлийн 40 мянган үсгийн тэмдэгтэй тэнцэнэ. Бүх үсэг, тоо, цэг тэмдэг, үгийн хоорондын зай, дутуу төгссөн мөрийн эцсийн зайг цөм үсгийн тэмдэгт гэж тооцоолно. Зохиогчийн хуудас нь шүлгийн 700 мөр буюу хэвлэсэн ном дахь 3000 хавтгай, дөрвөлжин сантиметр талбай бүхий зурагтай тэмцэнэ” гэж тайлбарласан байна.

Мөн “Бумажный лист” (нэгж хуудас, цаасан хуудас) гэдгийг “Аливаа ном хэвлэлд зайлшгүй орох цаасны хэмжээг тооцоолох нэгж. Номын хэвлэх тоо, багтаамжийг мэдсэний дараа түүнийг хэвлэхэд хэрэглэх цаасны тоог хялбархан гаргаж болно. Ингэж тооцоолохдоо номын ерөнхий багтаамж буюу хэвлэлийн хуудсыг, түүнийг хэвлэх тоо ширхэгээр үржүүлж, гарсан тоог хоёрт хуваадаг” гэх мэтээр тайлбарлажээ. Ийм наад захын мэдлэг өнөөгийн залуу сэтгүүлчдийн олонхонд байдаггүй нь нууц биш билээ. Энэ мэтээр сэтгүүл зүй, ном хэвлэлийн талаар гаргасан түүний бүтээлийн ач тусыг яриад байвал олон хуудас хэрэгтэй болно.

И.Дамбажав Монголын сэтгүүл зүйн судлаач, нэртэй ариутган шүүгч төдийгүй, сонины бичлэгийн олон зүйл, хэлбэрийг гарамгай эзэмшсэн уран бүтээлийн их чадвартан юм. Үүнийг удаа дараа хэвлүүлсэн найруулал, тэмдэглэлүүдийнх нь түүврээс мэдэж болно. Тийм номын нэг нь 1987 онд хэвлүүлсэн "Сэтгэлийн утас" гэдэг бүтээл мөн. Уг номонд зохиогчийн 15 найруулал, 7 сурвалжлага, мөн тийм тооны өгүүллэг оржээ.

Тэрбээр нам, засгийн төв хэвлэлд олон жил ажиллаж, ялангуяа бусдын бичсэнийг шүүн тунгааж, шүүмжлэн зөвлөх хариуцлагатай ажил эрхэлдэг хүний хувьд өөрөө бүтээл туурвилдаа нэн чамбай ханддаг сэтгүүлч юм. Аливаа ном бүтээл эцсийн эцэст амьдрал ахуйгаа л тусгадаг. Тэр ч жишгээр И. Дамбажавын "Сэтгэлийн утас" номын баатрууд нь бүхнийг бүтээн байгуулах үйлсэд зориулж байсан социализмын үеийн хөдөлмөрийн сайчууд, шинийг санаачлагчид байна. "Найруулал" моодонд орж, түүнийг бичигчид олширч байсан үед И.Дамбажав ид бүтээж туурвиж явжээ. Гэвч түүний найрууллууд нэг онцлогтой. Найрууллынхаа баатрыг унтах нойр, идэх хоолоо мартсан "ажлын мал" болгож дүрсэлдэг хэвшмэл загварт тэр ороогүй юм. Харин эх сурвалжаа

нухацтай судалсны үндсэн дээр баатрынхаа зан төрхийн онцлог, ухаалаг чанар, хандлагыг түлхүү харуулж, хүнд хэрэг болох санааг шингээж өгөхийг эрмэлздэг нь түүний найруулал бичлэгийн арга юм. "Булуу" тэрэгний Банзрагч", "Уран Цэвэл", "Алтан сор", "Сэтгэлийн утас", "Амьдралын харгуй", "Мөнгөн хөлгийн дуу", "Соён гэгээрүүлэгч" гэх зэрэг олон найруулалдаа И.Дамбажав, гол төлөв хөдөлмөрийн явцад хүмүүжиж төлөвшөөд, улмаар эх орныхоо хөгжил дэвшлийн төлөө хүч мэдлэгээ зориулахаар сэтгэл шулуудсан ажилчин, малчин, сэхээтний идэвхтэй дүрийг бүтээжээ. Түүний бичсэн "Алтан сор" гэдэг найрууллыг онцлон нэрлэе. Уг найруулал "Хүслийн жигүүр", "Их санаачилгын эхлэл", "Түгжжавын бар", "Алтан сор бүтээгчийн өрөөнд" гэсэн дөрвөн хэсгээс бүрдэх бөгөөд зохиомжийг их нарийн бодож хийснээрээ онцлог юм.

«

И.Дамбажав Монголын сэтгүүл зүйн судлаач, нэртэй ариутган шүүгч төдийгүй, сонины бичлэгийн олон зүйл, хэлбэрийг гарамгай эзэмшсэн уран бүтээлийн их чадвартан юм.

Үүнийг удаа дараа хэвлүүлсэн найруулал, тэмдэглэлүүдийнх нь түүврээс мэдэж болно. Тийм номын нэг нь 1987 онд хэвлүүлсэн "Сэтгэлийн утас" гэдэг бүтээл мөн.

»

гэсэн дөрвөн хэсгээс бүрдэх бөгөөд зохиомжийг их нарийн бодож хийснээрээ онцлог юм.

Найруулалд Арьс ширний артелийн инженер В.Түгжжавын ажил үйлс, зан төрхийг харуулжээ. Тэр нь хонь, ямаанаас эхлээд чоно, нохойг хүртэл харсан үзсэн амьтан болгоныхоо үс ноосыг будгийн бус аргаар өөрчлөн хувиргах "донтой" болчихсон хүн юм.

Анх 1965 онд залуухан инженер Болгарын хоршооллын байгууллагын 70 жилийн ойд зочноор уригдаж явахдаа ан

амьтны арьс ширэн бүтээгдэхүүний үзэсгэлэнд тавигдсан хонины арьсыг үнэгнийх хэмээн эндүүрэх шахаж, түүнийг боловсруулсан аргыг онцгой сонирхжээ. Тэр цагаас хойш амьтны үс арьсыг аль таваарлаг амьтны үс арьстай адилхан болгож боловсруулах аргыг уйгагүй эрж амжилт олсон тухай уг найруулалд өгүүлж байна. Тэхдээ сонирхолтой өгүүлэх арга боломжийг эрэлхийлсэн нь найрууллын хэсэг, өгүүлэмж бүрээс тодорхой харагдаж байна. Жишээ нь "Үзэсгэлэнгийн танхимын нэг буланд дэлгэн тавьсан том шар эрээн "бар" үзэгч олны харааг арга буюу булааж байв. Энэ сонин үзмэрийг нүд хужирлан харж байсан Польш орчуулагч Демский:

- Танай энд зоопарктай юу? гэж манай худалдааны төлөөлөгч асууж байна гэв. Тайлбарлагч:

- Үгүй ээ. Манайд зоопарк байхгүй.

- Тэгвэл Уссурийн бар хаагуур тэнэж яваад танай үзэсгэлэнд морилж ирдэг билээ?

- Үгүй ээ. Энэ бол Уссур нутгийн бар биш. Зүүн хойд Азийн Уссур нутагт ийм бар бий нь бий. Гэхдээ энэ бол Улаанбаатарын бар байгаа юм гэж тайлбарлагчийг инээмсэглэн өгүүлэхэд худалдааны төлөөлөгч нүдээ том болгож гайхсанаа:

- Улаанбаатарт ийм бар байна гэж үү? гэв.

- Тийм ээ. Улаанбаатарт байгаа юм. Гэхдээ та наад барынхаа сүүлийг нь ажиглаад орхиоч! гэж тайлбарлагчийг инээмсэглэн өгүүлэхэд тэр хүн нүднийхээ шилийг авч тонгойн харснаа, тас тас инээж:

- Өө уучлаарай. Нээрэн тийм байна. Чонон сүүлтэй бар байна л даа гээд дахин инээхэд тайлбарлагч:

- Түүнийг бид "Түгжжавын бар" гэдэг юм хэмээн өгүүлэв гэхчилэн бичсэн бий. Түгжжав амьтны арьс үсийг спектрийн аргаар танигдахгүй болтол нь өөрчилж чаддаг гэж хэд хэлээд ч хүний ой тойнд дээрх өгүүлэмж шиг төсөөлөгдөн буухгүй. Баримтыг уран сайхны аргаар боловсруулах найрууллын зарчимд дээрх өгүүлэмж гойд нийцэж байгаа юм.

Найрууллыг урлах ийм арга ганцхан энэ бичлэгт байгаа юм биш, бараг бүх найруулалд нь байгаа юм. Үг, дүрслэл болгоноо сэтгэлдээ ургуулж, даацтай боловсруулж бичдэг нь И.Дамбажавын өвөрмөц барил ажээ.

И. Дамбажав бас сурвалжлагын их чадвартан юм. Тэрбээр "Хөдөлмөрийн амт", "Элдүүрчид", "Жигүүрт хөлгийн дөрөө", "Энхталын адуучин", "Эр хүний сайн хань", "Гурван өлгийн Манхан" зэрэг олон арван сурвалжлага бичжээ. Тэр найрууллыг зан төрхийн түүх гэж үздэг бол сурвалжлагыг ажил хэргийн түүх гэж үздэг нь бичсэн бүтээлээс нь харагддаг. Тэхдээ бас л сонирхолтой, дүрслэлтэй өөрөөр хэлбэл ажил хэрэг нүдэнд харагдаж байхуйцаар бичихийг эрхэмлэдэг байна. "Элдүүрчид" гэдэг сурвалжлагад 5000 килограмм ачаа өргөх чадалтай аварга том өргөгч цамхагийг залуухан бүсгүй дөрлөсөн мэт жолоодож явагч нүдэнд харагдтал дүрсэлсэн бол цехийн боловсруулах үйл ажиллагааг "Нар салхинд мод шиг болтол хатаж, хорчийсон арьс үйлдвэрийн хаалгаар оронгуут хүйтэн ваннанд "сууж" биеийнхээ чилээг гаргаж байхад, нөгөө хаалгаар нь таван зүйлийн тансаг сайхан өнгөөрөө хүний нүд булаасан

шевро болоод оёдол, гутлын үйлдвэрт, эсвэл Зөвлөлт, Польш ч юм уу, алс далайн тэртээх Куба орно гэж хүрэх газрынхаа хаягийг бичүүлээд машин "унан" гарч байгаа харагдана" гэхчилэн сонирхолтой өгүүлсэн байна.

И.Дамбажавын уран бүтээлийн нэг чухал чиглэл нь монгол хэлбичгийг цэвэр ариун байлгах, эх хэлнийхээ тансаг сайхныг хойч үедээ мэдрүүлж, өвлүүлэх явдал ажээ. Энэ зорилгоор сүүлийн 20 шахам жилд толь бичиг зохиох ажилд хүч мэдлэгээ зориулж яваа юм. Тэрбээр "Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж" хэмээх хоёр боть, тус бүр нь 1200 гаруй хуудастай бүтээл туурвисан нь монгол хэлний анхны дэлгэрэнгүй тайлбар толь болсон бөгөөд эрдэмтэн мэргэдээс өндөр үнэлгээ авсан билээ. Далаад мянган толгой үгээс бүтэх энэ толь бичигт үгийн гарал үүслийг зааж, хэлц үгийг олноор оруулж, үг бүрийг үгсийн айгаар ялгаж, кирил ба сонгодог монгол бичгийн хоёр толгой үгийг хадаж өгсөн нь орчин үеийн хүмүүсийн ашиглахад нэн хялбар болжээ. Манай оронд ялангуяа залуу үеийнхэн монгол туургатны бүтээж ирсэн мянга гаруй жилийн соёл, түүхийн алдартай сурвалж бичгүүдийг сөхөж, тэдгээрийг эрдэм сурлага, ажил амьдралдаа хэрэглэхэд нь энэ толь бичиг үнэтэй хувь нэмэр болно. Энэхүү толь бичиг Я.Цэвэлийн толиос толгой үгийн тоогоор ч, тайлбарласан хэлц үгийн тоогоор ч гурав дахин их юм. Я.Цэвэлийн толь 22.000 орчим толгой үгтэй бол И.Дамбажавын толь бичиг 70.000 гаруй толгой үгтэй бөгөөд 90.000 орчим хэлц үгийг оруулаад нийт-

дээ 150.000 монгол үгийг тайлбарласан байна.

Я. Цэвэлийн тольд тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалаад бурхан шашны холбогдолтой нэг ч үг ороогүй бол энэ толь бичигт монголын ард түмний уламжлалт шашин шүтлэгийн тухай 3.000 гаруй толгой үгийг шинээр оруулжээ. Түүнчлэн "Монголын нууц товчоо" болон "Гэсэр", "Жангар" зэрэг эртний дурсгалт бичигт гардаг монгол үг, Монголын уламжлалт анагаах ухаан, мал аж ахуйн тоног хэрэгслийн холбогдолтой үгсийг арвин хэмжээгээр оруулснаараа онцлог болжээ.

И.Дамбажавын өөр нэг томоохон бүтээл нь "Сонгодог монгол бичгийн хэлний үсгийн дүрмээр ангилсан монгол, орос толь бичиг" юм. Энэ бүтээл бүтцийн хувьд урьд өмнө гарч байгаагүй бөгөөд 36.000 орчим толгой үгийг багтаасан 1200 хуудастай ажээ. Уг толь бичиг кирил, сонгодог монгол бичгийн хоёр толгой үгтэйгээрээ өмнөх толиудаас онцлог бөгөөд монгол хэл судлалын салбарт гарсан цоо шинэ бүтээл болсон юм. Сонгодог монгол бичгийн зөв бичлэгийг аль болох үндэслэлтэйгээр тогтоосон эрдэм шинжилгээний энэ шинэлэг бүтээл нь сонгодог монгол бичгийг алдаагүй зөв бичихэд тулах үгэн таяг болох нь гарцаагүй.

И.Дамбажав монгол бичиг үсгийг хойч үед өвлүүлэн үлдээх, түүний гайхамшигт чанарыг товойлгон үзүүлж сурталчлах ажлыг уйгагүй хийж ирсэн зүтгэлтний нэг юм. "Дэлхий дахины соёлын далай баян санд монгол хүний нэмэрлэсэн хувь" гэдэг бүтээлээ тэрбээр гагцхүү энэ зорилгоор туурвижээ. Уг товхимолд

сонгодог монгол бичгийг хэрхэн бичих зарчмыг баримтлан зөв бичгийн дүрмийг найман бүлэг болгон ангилж, жийрэглэх буюу холбох эгшгийн дүрмийг тайлбарлаж, хувилагч төгсгөлтэй үгийн язгуурыг дангаар нь түүвэрлэсний дээр хичээнгүй бичгийн тайлбарыг хүснэгтээр хавсаргажээ. Мөн монгол бичгийн хэлний зүйн дүрмүүд, тэдгээрийг зохиогчдын товч намтар, монгол үсэг бичгийн өөр өөр хэлбэр дүрсүүд, тэдгээрийн онцлогийг энэ бүтээлд тодорхой тайлбарласан байна. И.Дамбажавын энэ бүтээл нь "Сонгодог монгол бичгийн хэлний үсгийн дүрмээр ангилсан монгол орос толь" гэдэг бүтээлтэй нь салшгүй холбоотой бөгөөд уг тольд оруулж амжаагүй хүснэгт, тайлбаруудыг нөхөн гүйцээсэн шинжтэй юм.

И Дамбажавын дурьдан бүхий толь бичгийг манай нэрт эрдэмтэн А.Лувсандэндэв, Чой.Лувсанжав, Л.Түдэв, Т.Дашцэдэн, Ц.Өлзийхутаг нар их өндөр үнэлснийг дашрамд тэмдэглүүштэй.

И.Дамбажавыг үгийн таягийг тулсан "Үнэн" сонины Их Хичээнгүй гэж нэрлэмээр санагдана. Тэрбээр утга соёл, үгийн урлагийн салбарт үнэхээр ихийг бүтээжээ. Зөвхөн түүний зохиосон хоёр том толь бичгийн дайтай бүтээлийг бүхэл бүтэн хэл зохиолын хүрээлэн өнөөг хүртэл хийж чадаагүй л байна. Сэтгүүл зүйн туурвилаараа ч тэр нэгэн үеийнхний манлайд явсан юм. Түүний сэтгүүл зүйн томоохон бүтээл, тухайлбал найруулал, тэмдэглэл, өгүүлэл, сурвалжлагын тоо 1500-аас хол давсаны дээр дэлхийн долоон хэлээр хэвлэгдсэн байдаг. Тиймээс ч тэрбээр 1985 онд

"Олон улсын сэтгүүлч" гэдэг эрхэм алдрыг гуйж биш, гуядаж авсан юм. И.Дамбажав сэтгүүл зүйн онолын өргөн мэдлэг, арвин туршлага эзэмшсэн бүтээлч сэтгүүлч бөгөөд сонины бичлэгийн хэл найруулгыг жигдрүүлж, нийтлэлийн утга зохиолын найруулгын хэм хэмжээ, тэг жаягийг тогтооход олон жилийн хөдөлмөрөө зориулсан гавьяат үйлстэн мөнөөс мөн билээ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Д а м б а ж а в И. 1984. Сонины өнгө зүс, дүр төрх. УБ.
2. Д а м б а ж а в И. 1986. Сонины онцлог үг хэллэг. УБ.
3. Д а м б а ж а в И. 1988. Сонин гаргах урлаг. УБ.
4. Д а м б а ж а в И. 1987. Сэтгэлийн утас. УБ.
5. Д а м б а ж а в И. 1987. Сонин хэвлэлийн нэр томъёоны товч тайлбар толь. УБ.
6. Д а м б а ж а в И. 1966. Сонгодог монгол бичгийн хэлний үсгийн дүрмээр ангилсан монгол орос толь. Прага.
7. Д а м б а ж а в И. 1997. Дэлхий дахины бичиг соёлын далай баян санд монгол хүний нэмэрлэсэн хувь. УБ.
8. Д а м б а ж а в И. 2007. Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж. УБ.

Summary

In this article ("The diligent man of newspaper "Unen" with a walking stick made of words") works of a senior journalist I.Dambajav are analyzed. His journalistic activities are discussed from the points of view as he is one of the founders of feature story and prose in Mongolian newspapers, and a great editor, as well as a talented manager of printing and conveying news. Moreover, his research and teaching of classical Mongolian scripts and his remarkable lexicography works of Mongolian language dedicated to young generations are highlighted.